

**ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЯА
ХҮМҮҮНЛЭГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН
ЭРДЭМТЭН БАГШ НАРЫН СУРГАЛТ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ-АРГА ЗҮЙН БОЛОН
БУСАД АЖЛЫН АЧААЛЛЫГ ТООЦОХОД БАРИМТЛАХ ЖУРАМ**

1. Багшийн сургалт-эрдэм шинжилгээний цагийн ачааллыг тооцох хөдөлмөрийн үнэлгээг бодож цалинжуулахад “Багш биелүүлэх кредит” цагийг (цаашид ББК) хэрэглэнэ. Энэ нь сургалтын ажлын (А), эрдэм шинжилгээ-арга зүйн (В) болон бусад ажлын (С) гэсэн гурван хэсгээс бүрдэнэ. ББК нь хичээлийн жилдээ 15 кредит цаг байна. Нэг хичээлийн жилд 15 кредит цаг заахад олгогдох хөлснөөс тооцон орон тооны багшийн нэг сарын үндсэн цалинг тогтооно.

Тайлбар:

ББК нь багшийн багц хөдөлмөрийг илэрхийлнэ. Үүнд тухайн хөтөлбөрийг оюутнаар эзэмшүүлэх үндсэн ажил лекц, семинар, лаборатори, дадлагын хичээл, тест болон шалгалтын материал, лекцийн материал бэлтгэх үйл ажиллагаа, онолын болон практик судалгаа, ном сурах бичиг, гарын авлага бичих, оюутнуудтай ажиллах, сургуулийн захиалгат ажилд оролцох зэрэг болно.

ББК нь бүрдвэрээрээ хөтөлбөр бүрд ялгаатай задлагдана.

Тухайлбал, зарим хөтөлбөр дан лекц+оюутны бие даалтыг үнэлэх ажиллагаанаас тогтох бол зарим хөтөлбөр лекц+семинар+оюутны бие даалт, улирлын явцыг үнэлэх ажиллагааг агуулна.

2. Багшийн ачаалал, хөдөлмөрийн үнэлгээг тооцохдоо багшид тэнхмээс ногдол хуваарилж хичээлийн жилд гүйцэтгэсэн сургалт, эрдэм шинжилгээ - аргазүйн ажил болон бусад ажлын гүйцэтгэлээр ББК-ийн гүйцэтгэлийг кредит цагаар бодно. Ийнхүү тооцохдоо мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд батлагдсан кредит цаг болон энэ журмын 4 ба 15 дугаар зүйлийн заалтыг баримтлана.

3. Багш нарыг эрдэмийн зэрэг цол, эрхэлж байгаа сургалт, судалгааны ажлын чанар, үр дүн, магистрант, докторантыг дагалдуулан сургах чадвар зэргийг харгалзан:

- a. Профессор
- b. Дэд профессор
- c. Багш
- d. Ассистент багш - гэсэн шатлалтай албан тушаалд хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулна.

Багш дээрх албан тушаалын алинд ажиллахаа өөрөө сонгох эрхтэй бөгөөд тухайн албан тушаалд нэр дэвшигч нь дараах шалгууруудыг хангасан байна.

ХДС-ийн **профессорын** албан тушаалд ажиллах багш нь сургалтын стандарт, агуулга, технологийг боловсронгуй болгох ажлыг тэргүүлэн гүйцэтгэж, бакалавр, магистрантур, докторантурын сургалтыг онолын өндөр түвшинд явуулах, магистрант, докторант залуу багш нарын эрдэм шинжилгээний ажлыг удирдан чиглүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны болон зорилтот төсөл боловсруулан хэрэгжүүлэх чадвартай докторын зэрэгтэй багш байна. **Профессорын ачаалалд сургалтын цаг 9 кр цаг, эрдэм шинжилгээний цаг 5 кр цаг, бусад ажил 1 кр цаг байна.**

ХДС-ийн **дэд профессорын** албан тушаалд мэргэжлийн үндсэн сургалтыг хариуцан заах, мэргэжлийн сургалтын стандарт, агуулга, технологийг боловсронгуй болгох, судалгааны болон зорилтот төсөл хэрэгжүүлэх чадвартай, магистраас дээш зэрэгтэй

багшийг ажиллуулна. **Дэд профессорын ачаалалд сургалтын цаг 11 кр цаг, эрдэм шинжилгээний цаг 3 кр цаг, бусад ажил 1 кр цаг байна.**

ХДС-ийн **багшийн** албан тушаалд мэргэжлийн чиглэлээр сургалтын агуулга, стандартыг боловсронгуй болгож, сургалтанд шинэ технологи нэвтрүүлэн ажилладаг, мэргэжлийн гол хичээлүүдийг заах өндөр чадвартай, сургалтын материал боловсруулах, оюутантай ажиллах туршлагатай магистраас доошгүй зэрэгтэй багшийг ажиллуулна. **Багшийн ачаалалд сургалтын цаг 13 кр цаг, эрдэм шинжилгээний цаг 1 кр цаг, бусад ажил 1 кр цаг байна.**

ХДС-ийн **ассистент багшийн** албан тушаалд мэргэжлийн өндөр чадвар эзэмшсэн, оюутантай ажиллах чадвар сайтай магистр зэрэгтэй багш мэргэжлийн хичээлүүдийг зааж ажиллана. **Ассистент багшийн ачаалалд сургалтын цаг 14 кр цаг, бусад ажил 1 кр цаг байна.**

Профессорын болон Дэд профессорын албан тушаалд ажиллах багшийг тэнхмийн хурлаас нэр дэвшүүлэн ХДС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.

4. Багшийг албан тушаалд ажиллуулахаар нэрийг нь дэвшүүлэхдээ энэ журмын 3-р зүйлд заасан үндсэн шалгуурыг баримтлана. Албан тушаалын шатлалаас хамааруулж хичээлийн жилд гүйцэтгэх гэрээт сургалт, эрдэм шинжилгээ - арга зүйн ажил, бусад ажлын хэмжээг дараах байдлаар тогтооно. Үүнд:

Сургалт, эрдэм шинжилгээ-арга зүйн ажил болон бусад ажлын харьцаагаар

№	Албан тушаал	Нормт цагийн хуваарилалт			Нийт биелүүлэх кредит
		Сургалт А	Эрдэм шинжилгээ-арга зүйн ажил В	Бусад ажил С	
1	Ассистент багш	14	0	1	15
2	Багш	13	1	1	15
3	Дэд профессор	11	3	1	15
4	Профессор	9	5	1	15

Шинэчилсэн сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан Багшийн кредит цагийн ачаалал А, В, С гэсэн гурван бүрэлдэхүүнтэй байна.

"А" цагийн бүтцэд:

- Бакалаврын болон магистрын түвшингийн бүх төрлийн сургалт хамрагдана.
- Багшийн үндсэн ачаалал нь бакалаврын өдрийн ангийн сургалтын цагаас бүрдэнэ.
- Багшийн үндсэн ачааллаас давуулан гүйцэтгэх кредит нь бакалаврын бусад төрлийн сургалт, магистрын сургалтын кредитийг багтаана.

"В" цагийн бүтцэд:

- сургуулийн захиалгаар гүйцэтгэх гэрээт судалгааны ажил, төсөл хэрэгжүүлэх, суурь судалгааны ажил
- Үндэсний их дээд сургуулиудын болон холбогдох докторантурын хороодоос хүлээн зөвшөөрсөн эрдэм шинжилгээний бичиг, Шинжлэх Ухааны Академийн эрдэм шинжилгээний бичигт хэвлүүлсэн бүтээл
- Гадаадын мэргэжлийн холбоод болон гадаадын их дээд сургуулиудын олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний бичигт хэвлүүлсэн бүтээл
- Олон улсын хэмжээнд зохиогдсон эрдэм шинжилгээний хурлын илтгэл

"С" цагийн бүтцэд:

- Сургуулийн болон захиргааны даалгавар нь бүх сургуулийн хэмжээнд гүйцэтгэгдэхээр байгаа болон захирлын тушаалаар үүрэг болгосон олон нийтийн ажил
- Мэргэжлийн чиглэлийн үйлчилгээ, /клуб, хамтлаг, багууд г.м/ хариуцахаар нэгж, салбартай байгуулсан гэрээний биелэлтэнд тооцох кредит цаг

5. Удирдах ажилтнуудын хичээлийн жилийн сургалтын кредит цагийн хэмжээг дараахи жишигийг баримтлан тогтооно. Үүнд:

- Салбар сургуулийн захирал, сургалтын төлөвлөлт-мониторингийн албаны дарга тус бүр 3 кредит, эрдэмтэн нарийн бичгийн дарга 6 кредит;
- Тэнхмийн эрхлэгч, лаборатор, төвийн эрхлэгч 12 кредит, тэнхмийн орлогч эрхлэгч 13 кредит гүйцэтгэнэ.

Тайлбар: Тэнхмээс хариуцаж буй мэргэжлийн сургалтанд хамрагдсан оюутны тоо, үйлчилгээний хүрээнээс хамааруулан тэнхмийн эрхлэгчийн биелүүлэх кредит, кредитийн хөнгөлөлтийг захирлын тушаалаар зохицуулж болно.

6. Зохиогч өөрийн судалгаанд үндэслэн боловсруулж Захирлын тушаалаар эрхийг нь баталгаажуулсан сонгон мэргэшүүлэх лекцийн 15 цагийг, семинар дадлагын 30 цагийг 1 кредитэд тооцно.

7. Хичээлийн бүлгийг дараахи байдлаар зохион байгуулна.

А. Ерөнхий суурь сургалтын нийтийн лекцийг 100–150, семинарын бүлгийг 40 оюутантайгаар, хэлний бага бүлгийг 20 оюутантайгаар зохион байгуулна (Оюутны хөтөлбөр сонголтоос шалтгаалан 20-оос цөөн оюутнаар бүлэг бүрдсэн тохиолдолд 1 кредитийн үнэлгээг ялгавартай тогтооно).

Б. Мэргэжлийн суурь:

- Гадаад хэлний лекцийн бүлэгт 25 хүртэлх оюутан, практик бүлэгт 20 оюутан,
- Нийгмийн ухааны лекцийн бүлэгт 100 - 150 оюутан, семинарын бүлэгт 20 - 30 оюутан байна.
- Мэргэшүүлэх болон сонгон мэргэшүүлэх хичээлийн бага бүлгийн оюутны тоо 20 - 30 байна.

8. Сургалтын чанарын баталгааг хангах зорилгоор нэг долоо хоногт багшийн гүйцэтгэх ачааллын дээд хязгаарыг хичээлийн жилийн эхэнд Захирлын тушаалаар тогтоож болно.

9 . Дээр заасан үндсэн зарчмуудыг баримтлан тухайн сургуулийн анги танхимийн онцлог, хүрэлцээ, хичээлийн өвөрмөц байдал, хичээлийг сонгосон оюутны тоо зэргийг үндэслэн сургалтын төлөвлөлт мониторингийн албанаас хичээлийн хуваарийг зохицуулан гаргах эрхийг эдэлнэ.

10. Улирал бүрийн эхэнд оюутнууд сургалтын төлөвлөгөөний дагуу сонгон судлах кредитээ төлөвлөн, гэрээлсэн дүнг үндэслэн тэнхмийн гүйцэтгэх ачаалал тодорхойлогдоно.

11. Оюутны хийсэн хөтөлбөр сонголтыг үндэслэн тэнхмийн эрхлэгч багш нарын биелүүлэх кредит цагийн ачааллыг тэнхмийн хэмжээнд тооцож зохих орон тооны жишиг болон багш нэг бүрийн ноогдлыг тогтооно.

12. Нэмэлт кредит сонгон суралцах оюутнуудын бүлгийн бүрдэлт, сонгосон кредитийг тооцохдоо сонгох сургалтын журмын заалтыг үндэслэн захирлын тушаалаар баталгаажуулна.

13. Оюутан мэргэжлийн суурь болон сонгон мэргэшүүлэх хөтөлбөрөөр дипломын ажил гүйцэтгэж болно. Дипломын ажлыг гүйцэтгэхэд тусгай журам баримтлана.

14. Эрдэмтэн багш нарын А, В, С цагийн биелэлтийг тэнхмээс доорхи үзүүлэлтээр дүгнэн холбогдох кредит цагийг тооцно.

А. Сургалтын ажил

№	Ажлын хэлбэр	Гүйцэтгэлийг тооцох кредит цагийн хэмжээ
---	--------------	--

1	Лекц, семинар, лаборатори	Сургалтын төлөвлөгөөнд заасан кредит цагийн гүйцэтгэлээр тооцно.
---	---------------------------	--

В. Эрдэм шинжилгээ – арга зүйн ажил

№	Ажлын хэлбэр	Гүйцэтгэлийг тооцох кредит цагийн хэмжээ
1	Оюутны дипломын ажил, эрдэм шинжилгээний ажил хийхэд ашиглах шинжлэх ухааны туршилт, судалгааны аргачлал бичиж эрдмийн зөвлөлөөр батлуулж сургалтанд шилжүүлэх	Батлагдсан аргачлал бүрт 1 кредит цаг
2	Оюутны бие даалтын ажлын сэдэвчилсэн гарын авлага хийсэн, улирлын болон батлах шалгалтын, хөтөлбөрийн иж бүрдэл тест хийж, тэнхмийн хурлаар батлуулж, хэвлүүлсэн бол	Нэг хэвлэлийн хуудаст 0,3 кредит цаг
3	Зайн болон онлайн сургалтын гарын авлага хийж тэнхмийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан, сургуулийн хэвлэлээр хэвлүүлэн сургалтанд шилжүүлсэн, сүлжээнд нийтэлсэн	Нэг хэвлэлийн хуудаст 0,4 кредит цаг
4	ХИС-ийн болон Үндэсний их, дээд сургуулиудын, холбогдох докторантурын хороодоос хүлээн зөвшөөрсөн эрдэм шинжилгээний бичигт хэвлүүлсэн бүтээл	Нэг хэвлэлийн хуудаст 0,3 кредит
5	Шинжлэх Ухааны Академийн эрдэм шинжилгээний бичигт хэвлүүлсэн бүтээл	Нэг хэвлэлийн хуудаст 0,3 кредит
6	Гадаадын мэргэжлийн холбоодын сэтгүүлүүд, гадаадын их дээд сургуулиудын олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний бичигт хэвлүүлсэн бүтээл	Нэг хэвлэлийн хуудаст 0,75 кредит
7	Олон улсын хэмжээнд зохиогдсон эрдэм шинжилгээний хурлын илтгэл	Нэг хэвлэлийн хуудаст 0,75 кредит

Тайлбар: “В” цагийг гүйцэтгэлээр олгох бөгөөд гүйцэтгэлийг тооцохдоо дараах журмыг баримтална.

- Сургуулийн захиалгаар гүйцэтгүүлэх судалгааны ажлын сэдэв, чиглэл болон гэрээний нөхцөл, шалгаруулах үзүүлэлтүүдийг Эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн батлана.
- Сургуулийн захиалгат судалгааны ажлыг гүйцэтгэх эрдэмтэн багш нарын баг, судалгааны хамтлагийг 10 сард багтаан мэргэжлийн комисс шалгаруулна.
- Сургуулийн захиалгат болон гэрээт эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг жил бүрийн **12** болон **5** дугаар саруудад мэргэжлийн эрдэмтэн шинжээчдийн комиссоор хэлэлцэн дүгнэж байна.

С. Бусад ажил

№	Ажлын хэлбэр	Гүйцэтгэлийг тооцох кредит цагийн хэмжээ
1	Захиргаа олон нийтийн ажил	Захирлын тушаалаар томилогдсон комисс захиргааны болон олон нийтийн шинж чанартай ажил үйлчилгээ хийж гүйцэтгэсэн тохиолдолд хичээлийн жилийн сар тутам 0,3 кредит
2	Тэнхим, мэргэжлийн чиглэлийн үйлчилгээ	Мэргэжлийн сурталчилгаа, корпоратив сургалт, мэргэшүүлэх чиглэлээр оюутны клуб, хамтлаг болон бусад олон нийтийн байгууллага хариуцан ажилласан бол хичээлийн жилийн сар тутам 0,15 кредит

3	Хөтөлбөрийн координатор	Хөтөлбөрийн координаторийн тайланг үндэслэн семестерт 1.0 – аас доошгүй кредит тооцох. Кредитийн хэмжээг тухайн хөтөлбөрт хамрагдаж буй оюутны тооноос хамааруулан тооцно.
---	-------------------------	--

Тайлбар: “С” цагийг гүйцэтгэлээр олгоно.

16. Эрдэмтэн багш нарын хичээлийн жилд гүйцэтгэвэл зохих сургалтын ажлын кредит цагийн хэмжээг дор дурдсан тохиолдолд тухайн багшийн өдрийн нормоор бодож хорогдуулна.

Үүнд:

- Хичээлийн жилийн дундуур ажилд шинээр томилогдсон, ажлаас чөлөөлөгдсөн буюу халагдсан
- Мэргэжил дээшлүүлэх курст суралцсан
- Жирэмсний ба амаржсаны дараах амралттай байсан, нярай хүүхэд асрах чөлөөтэй байсан
- Ажлын долоо хоног ба түүнээс дээш хоног захиргааны чөлөөтэй байсан, сургуулийн томилолтоор гадаад, дотоодод ажилласан, хөдөлмөрийн чадвараа түр алдсан.
- Магистратур, докторантурын шалгалт өгөхөөр чөлөөлөгдсөн.

17. Багшлах дадлагын хугацааны долоо хоног тутамд нэг оюутан дан мэргэжлээр 1 цаг, хос мэргэжлээр 2 цагийн дүн хамгаалах хичээл заана.

18. Мэргэжлийн багш дутагдалтай нөхцөлд зарим хөтөлбөр, курсыг цагийн багшаар заалгаж болно. Цагийн багшийн хичээл заах үнэлгээг Захирлын тушаалаар баталгаажуулна.

19. Тэнхмийн эрхлэгч нь эрдэмтэн багш нарын цагийн ачааллыг тогтсон жишгээр орон тоонд нь багтаан оюутны сонголтын дагуу хуваарилах үүргийг гүйцэтгэнэ. Цагийн ачааллыг буруу тогтоосоны эдийн засгийн хариуцлагыг тэнхмийн эрхлэгч хүлээнэ.

Багш хичээлийн жилд 15 - 17 кредит цаг зааж буй бол хэвийн ачаалалтай гэж үзнэ. Багшид тэнхмээс хуваарилсан ачааллыг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Хэт бага 1 – 11 кредит
- Бага 12 – 14 кредит
- Хэвийн 15 – 17 кредит
- Их 18 – 20 кредит
- Хэт их 21 – ээс дээш кредит

Хэт бага, бага кредитийг цагийн багш нарт гэрээний үндсэн дээр тэнхмийн эрхлэгч зохицуулан хуваарилна.

20. Тэнхмийн эрхлэгч эрдэмтэн багш нэг бүрийн гүйцэтгэсэн ажлын тооцоог хичээлийн жилийн сар, улирал тутам нормт цагийн бүрдвэрээр гаргаж, салбар сургуулийн захиргаанд тайлан гаргаж байна. Тэнхмийн эрхлэгч нь тэнхмийн багш нарын ээлжийн амралт, цалингийн тооцоог хянаад салбар сургуулийн захирлаар батлуулж санхүүтэй тооцоо хийнэ.

21. Сургуулийн захиргааны шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн, мэргэжил дээшлүүлсэн, өвчилсөн, нярай хүүхдээ асрахаар чөлөөтэй байсан багшийн оронд нэмж заасан цагийн хөлсийг тухайн сард нь тооцож олгоно.

22. Докторант багшид урьдчилсан хамгаалалтад ороход 1 сарын, жинхэнэ хамгаалалтад ороход 2 сарын цалингийн дундажтай тэнцэх цалинтай чөлөө олгоно.

23. Сургалтын нормт цагт орж тооцогдохгүй, сургалттай холбоотой ажлын гүйцэтгэлийг дараах байдлаар тооцоолж олгоно.

№	Ажлын хэлбэр	Гүйцэтгэлийг тооцох кредит цагийн хэмжээ
---	--------------	--

1	Дипломын ажил удирдах. - Бакалаврын зэргийн - Магистрын зэргийн	Хамгаалуулах комиссын зөвлөмжийг үндэслэн үндсэн багшид бакалаврын зэргийн ажилд 1,0 хүртэл, магистрын зэргийн ажилд 1,25 хүртэл кредит цаг тооцно.
2	Дипломын ажилд шүүмж бичих. - Бакалаврт - Магистрт	- Ажил бүрт 0,1 кредит цаг - Ажил бүрт 0,3 кредит цаг
3	Багшлах дадлага удирдан тайлан хамгаалуулах	Оюутан бүрт дадлагын хугацааны 7 хоног тутамд 0,085 кредит цаг
4	Сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх дадлага удирдах	Оюутан бүрт дадлагын хугацааны 7 хоног тутамд 0,025 кредит цаг
5	Орчуулгын дадлага удирдан тайлан хамгаалуулах	Оюутан бүрт дадлагын хугацааны 7 хоног тутамд 0,07 кредит цаг
6	Хээрийн дадлага удирдан тайлан хамгаалуулах	10-20 хүнтэй бүлэгт өдөрт 0,2 кредит цаг
7	Үйлдвэрлэлийн дадлага удирдан тайлан хамгаалуулах	Оюутан бүрт дадлагын хугацааны 7 хоног тутамд 0,07 кредит цаг
8	Ажиглах дадлага удирдсан багшид	Оюутан бүрт дадлагын хугацааны 7 хоног тутамд 0,35 кредит цаг
9	Онлайнаар суралцаж буй оюутнуудад хичээл зааж буй багшид, сургалтын төлөвлөгөөг экстернат хэлбэрээр хэрэгжүүлэн оюутан сурах ганцаарчилсан төлөвлөгөөг хийж, зөвлөх багшаар ажилласан	Онлайнаар суралцаж буй оюутнуудад хичээл зааж буй тохиолдолд оюутан нэг бүрт улирал тутамд 0,5 кредит
10	Төгсөлтийн шалгалт авах, стандарт – экспертийн батлах шалгалт авч дүгнэлт бичихэд	- Өдөрт 30 оюутан шалгахаар бодож шалгалтад ажилласан цагийг кредит цагт шилжүүлэн комиссын гишүүн тутамд 0,3 кредит цаг хүртэл, - Батлах шалгалт авсан ассистент багшид шалгалт тутамд 0,066 кредит - Стандартын тест боловсруулахад шалгалтын багц тестэд 0,2-0,3 кредит - батлах шалгалтын ажил засахад оюутан тутамд 0.0055 кредит, - Их семинарын болон магистр докторын хамгаалуулах зөвлөлийн дарга, гишүүдэд холбогдох эх үүсвэрээс ХДС-ийн захирлын тушаалаар бодит цагаар тооцно.
11	Хөтөлбөрийн агуулга стандарт шинэчлэн боловсруулсан, үнэл-гээ хийж дүгнэлт өг-сөн хөтөлбөр тутамд	- Хөтөлбөр тутамд 0,2 – 0,4 кредит
12	Кредит нөхөн судалж буй оюутнуудад хичээл заасан тохиолдолд	- Кредитийн үнэлгээний 50%

24. Сургуулийн захиалгаар болон эрдэм шинжилгээний ажлаар шинжлэх ухаануудын зааг дээр хийгдсэн шинжлэх ухаан технологийн шинэ шийдэл бүхий судалгааны ажлын үр дүн нь дэлхийд тэргүүлэх хөгжилтэй орнуудад шинжлэх ухааны шагнал авсан, бүтээл нь тус сургуулийн үйл ажиллагаанд нэвтэрсэн тохиолдолд бие даасан судлаачид 0,5 саяас 1 сая төгрөгийн , судалгааны хамтлагт нь 1–1,5 сая төгрөгийн урамшил олгоно.

25. Сургуультай тогтвортой ажиллах гэрээ байгуулсан, сургуулийн захиалгат сэдвээр эрдмийн зэрэг хамгаалсан багшид 300000 төгрөгийн урамшил олгоно.

26. Дэлхийн шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлүүдээр судалгааны багийн ажлын төсөл шалгаруулж, шалгарсан эрдэм шинжилгээ, судалгаа арга зүйн нэг төслийг сургуулиас санхүүжүүлж болно.

27. Дотоодын их сургуулийн докторантурт суралцдаг ХДС – ийн багш нарын сургалтын төлбөрийг тодорхой гэрээний үндсэн дээр 500000 төгрөг сургуулиас санхүүжүүлнэ.

28. 7, 8 сард оюутны дадлага удирдсаны хөлсийг тусгайлан бодож олгоно

29. Багш нарт 1 ба 6 дугаар сард ажилласаны цалинг 9–12 ба 2–5 дугаар саруудад авсан цалингийн дунджаар, сарын дундаж цалин нь ББК-ийн дээд хязгаараар бодогдох нэг сарын цалингаас хэтрэхгүй байхаар бодож олгоно. Энэ дундаж цалинд элсэлт, төгсөлт, батлах шалгалтын хөлсийг давхардуулан олгохгүй.

30. Стандартын өндөр түвшинд сургалт явуулсан багшид сургалтын төлөвлөлт–мониторингийн албаны болон шинжээчдийн үнэлгээг харгалзан чанарын нэмэгдэл олгоно.

Сургалтын чанарын нэмэгдэл нь олгоход баримтлах шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Нэмэгдэл хувь
Оюутны сурлагын амжилтын түвшин – 10 хувь	50 хувь
Технологид суурилсан сургалтын түвшин – 15 хувь	
Сургалтын материал сайжруулалт – 15 хувь	
Ажлын хариуцлагын түвшин – 10 хувь	
Хөтөлбөрийн түвшин	
- бакалавр	0 хувь
- магистр	20 хувь
- доктор	30 хувь
Ажилласан жил	
1 – 5 жил	0 хувь
6 – 10 жил	30 хувь
11 – ээс дээш жил	40 хувь

31. Эрдэмтэн багш хичээлийн жилд гүйцэтгэх ажлаа хүндэтгэх бус шалтгаанаар биелүүлээгүй бол дутуу гүйцэтгэсэн ажлын хөлсийг амралтын хугацааны цалингаас суутгана.

32. Эрдэмтэн багш нарт эрдмийн зэрэг, цолноос шалтгаалж тогтмол нэмэгдэл олгоно.

Эрдмийн зэрэг, цол	Нэмэгдэл хувь
Доктор (Sc.D)	30 хувь
Доктор (Ph.D)	15 хувь
Профессор	10 хувь
Дэд профессор	5 хувь

33. Багш хуваарьт кредит цагаа заагаагүй, хожуу эхэлсэн, эрт тараасан бол уг хугацаанд ноогдох кредит цагийн мөнгийг дараах сарын цалингаас нь суутгана. Тасарсан

хичээлийг уг багш нөхөн зааж оюутныг хохиролгүй болгох бөгөөд суутгасан мөнгийг эргүүлэн олгохгүй.

34. Диплом хамгаалалт, батлах шалгалтад орсон оюутны тоог тооцохдоо кредит баталгаажуулсан тухай захирлын тушаалд орсон оюутны тоо, нэрсийн жагсаалттай тулгаж тооцно. Дипломын төсөл, ажлын хамгаалалт, батлах болон түүнтэй ижилтгэх шалгалтын комиссын гишүүний ажлын хөлсийг ХДС-ийн танхимийн сургалтын нэг цагийн үнэлгээгээр тооцож олгоно.

35. Сургалтын зайлшгүй шаардлагыг үндэслэн хэлний бус ангид мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг гадаад хэлээр заахаар захиргааны зөвлөлөөс зөвшөөрч баталсан бол ББК-ийн сургалтын цагийн хөлсийг 10–30 хувиар нэмэгдүүлэн тооцно. Ийн тооцуулах саналыг тэнхим, салбар сургуулиас гаргаж холбогдох шийдвэрийг захирлын тушаалаар баталгаажуулна.

36. Тухайн хичээлийн жилд захирлын тушаалаар баталсан сургалтын ажлын нормын дээд хязгаараас давсан бол илүү биелүүлсэн кредитийн үнэлгээг тухайн хөтөлбөрийн кредитийн үнэлгээний 75 хувиар бодож профессор, багшид олгоно.

37. Хөтөлбөрийн агуулгын онцлогоос хамаарч тэнхим, холбогдох нэгж нь гэрээт профессор, багшийг гадаад, дотоодын их, дээд сургуулиас урьж ажиллуулж болно. Гэрээт профессор, багшийг зөвхөн захирлын тушаалаар баталгаажуулах ба түүний гүйцэтгэсэн сургалтын ажлын хэмжээг энэ журмын хүрээнд, ажлын хөлсийг байгуулсан гэрээний нөхцлөөр тус тус тооцон бодож олгоно. Сургууль үндсэн багшийг өндөр эрэмбэ, өндөр зэрэглэлийн хөтөлбөр заалгаж ажиллуулж болно Гадаадын харъяат багшийн цалинг гэрээний үндсэн дээр тогтооно.